Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Төлбөрийн тэнцэл хариуцсан мэргэжилтэн, Жамбалбавуу Өлзийсайхан

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулна. | | | | | | | |
| 1 | Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана. | Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" батлуулсан. | - | 2025 оны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг боловсруулан ажилласан. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний нь “Эдийн засгийн өсөлтийн өгөөжийг өрх бүрд хүргэх” гэсэн зорилгын хүрээнд “Эдийн засгийн тогтвортой өсөлтийн бодлого”, “Эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэх хүний хөгжлийн бодлого”, “Шинжлэх ухаан, дэвшилтэт технологид | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тулгуурласан засаглалын бодлого", "Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах бодлого", "Ногоон хөгжлийн бодлого", "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Улаанбаатар хотын бүсчлэл- 20 минутын хотын бодлого", "Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх" гэсэн бодлогын 8 тэргүүлэх чиглэлийг тодорхойлж тусгасан. | | |
| 2 | Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг гүйцэтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" батлуулсан. | - | Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай импортын бараа бүтээгдэхүүний тоо мэдээлэл шинжилгээ хийж, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл болон 2025 оны төсөөллийг хийж, нэгдсэн макро эдийн засгийн танилцуулгыг нэгтгэн боловсруулсан. Монгол Улс 2023 онд дэлхийн 160 улстай худалдаа хийлээ. Өнгөрсөн 2023 онд экспортын барааны урсгал нэмэгдэж, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | импортын барааны үнийн өсөлтийн дараа бага байснаар гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн оноос 23 хувиар өсөж, 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарлаа<br>Хавсралт: 1 файл | | |
| 3 | Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсан. | Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2025 оны тооцоо, төсөөлөл, тэргүүлэх чиглэлийн танилцуулгыг боловсруулсан байна/ 1 танилцуулга/ | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль төслийг боловсруулахтай холбоотойгоор 2025 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэл, төсөөллийг боловсруулж хүргүүлсэн. Эдийн засгийн өсөлт тогтвортой байж, бизнесийн зээл олголт нэмэгдэж байгаагийн нөлөөгөөр уул уурхай, барилга, үйлдвэрлэлийн салбарын тоног төхөөрөмж, материалын импорт өсөхөөр байна. Мөн өрхийн орлого өсөж, хэрэглээний зээл олголт нэмэгдсэнээр хүнс, хэрэглээний бараа, шатахуун | 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зэрэг бүтээгдэхүүний импорт өснө. Нийт импорт 2024 оны эцэст 11.8 тэрбум ам.долларт хүрч өсөх төлөвтэй байна. Мөн эдийн засгийг тэлэх томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын ажил эрчимжиж, шинээр том төсөл эхлүүлснээр тоног төхөөрөмж, барилгын материалын импорт өснө. Ингэснээр 2025 онд нийт импорт 13.6 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна. Мөн бараа, бүтээгдэхүүнийг импортлохтой холбоотой бүртгэлийг автоматжуулж, боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг өргөжүүлж, нэг боомт дээр төвлөрсөн ачааллыг бууруулснаар импортын барааны эргэлтийн хурд нэмэгдэхээр хүлээгдэж байна.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.2. Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлно. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macro diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулж, танилцуулна. | Дүн шинжилгээний тоо | Өмнөх онуудын эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн. | 2024 оны 2, 3 дугаар улирлын танилцуулга бэлтгэсэн байна. | Монгол Улсын эдийн засгийн 2023 оны 4 дүгээр улирал, 2024 оны 1, 2, 3 дугаар улирлын гадаад худалдааны нөхцөл байдалд дүн шинжилгээ (Macro diagnostics) хийж, улирлын тайланг төлөвлөгөөт хугацаанд боловсруулан, яамны веб хуудсанд байрлуулж, хэвлүүлэн холбогдох байгууллага, судлаачид, иргэдэд хүргүүлээд байна. Экспортын орлого 2024 оны гуравдугаар улиралд өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өсөж, өмнөх улирлын өсөлтийн хурдыг давлаа. Үүнд, чулуун нүүрс, төмрийн хүдрийн биет хэмжээ нэмэгдсэн, дэлхийн зах зээл дэх алт, зэсийн үнэ өссөн нь зэрэг нөлөө үзүүллээ. Оны сүүлийн улиралд нүүрс, зэсийн баяжмалын биет хэмжээний өсөлт, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дэлхийн зах зээл дэх цэвэр зэс, алтны өндөр үнэ нь экспортын өсөлтийг дэмжихээр байна. Уул уурхайн экспортын үйл ажиллагааны идэвхжилийн нөлөөгөөр тоног төхөөрөмж, том машин механизмын импорт нэмэгдсэний зэрэгцээ зээл олголт эрчимжиж, өрхийн орлого сайжирснаар нийт импортын дүн өмнөх оны мөн үеэс 27 хувиар өслөө. Хавсралт: 3 файл | | |
| 5 | Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөлд ашиглана. | Хөгжүүлсэн загварын тоо | Мэдээллийн дата баазыг бүрдүүлж, туршилт тооцооллуудыг гүйцэтгэсэн. | Загвар хөгжүүлсэн байна /1 загвар/ | Нөөц, ашиглалтыг хүснэгтийг ашиглан салбар хоорондын тэнцлийг байгуулж, салбаруудын шүржүүлэгчийг ашиглан төсвийн хөрөнгө оруулалтын импортод нөлөөлөх тооцож төсөөлөл хийхэд ашиглаж байна. | 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 6 | Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр | Мэдээллийн тоо /Тоо/ | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн. | Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/ | 2023 оны 1-ээс 11 дүгээр сарын тоо мэдээлэлд сар бүр дүгнэлт хийж, сарийн мэдээний | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллээр хангана | | | | танилцуулга бэлдэж удирдлагуудыг мэдээллээр хангаж, яамны цахим хуудсанд байрлуулсан. Хавсралт: 5 файл | сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 7 | Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана. | Мэдээллийн тоо /Тоо/ | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн. | Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/ | Гадаад худалдааны голлох тоо мэдээлэл болох экспорт, импортын өдөр тутмын мэдээлэл, хилээр орсон болон гарсан машин, дэлхийн зах зээл дээрх голлох түүхий эдийн үнэ, гадаад валютын ханшийн мэдээллийг өдөр бүр нэгдсэн системд оруулж, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан. Нийт экспорт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын долоо хоногийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажилласан. Мөн уул уурхайн биржийн өмнөх өдрийн арилжаа, дэлхийн зах зээлийн үнийн мэдээлэл, болон зарим голлох бүтээгдэхүүний | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | экспорт, импортын тоонд дүн шинжилгээ хийж, өдөр бүрийн хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан | | |
| 8 | Дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, И-баримт гэх мэт) | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн. | Тайланд ашигласан тоо | Улирлын тайланд ашигласан байна. | Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан бүртгэдэг e-balance нэвтрэх эрхийг Сангийн яамнаас авсан ба дата баазыг нэгтгэсэн байдлаар авах буюу тус системд хандах чиглэлээр тус яамтай хамтран ажиллахаар төлөвлөн байна. Түүнчлэн дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж, эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macro diagnostics) тутмын танилцуулгад гаалийн дата, И-баримтын датаг боловсруулан гадаад худалдааны нөхцөл байдал, борлуулалтын нөхцөл байдалд шинжилгээ хийн тусгасан болно. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Эдийн засгийн урт хугацааны хандлагын судалгааг боловсруулна. | Судалгааны тоо | Судалгаанд шаардлагатай тоон мэдээллийг цуглуулсан. | Судалгаа боловсруулсан байна. /1 судалгаа/ | Эдийн засгийн салбаруудын чиг хандлагыг үнэлж, эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй салбаруудын хувь нэмэр, эдийн засгийн бүтцэд дүн шинжилгээ хийж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх бодлого боловсруулах зорилтын хүрээнд урт хугацааны эдийн засгийн хандлагын судалгаа хийж, танилцуулга бэлтгэж ажилласан. Судалгааны үр дүнд Ковид-19 цар тахал болон нийлүүлэлтийн саатлаас шалтгаалан тээврийн болон бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж импортын барааны зардал нэмэгдсэнээр 2021 болон 2022 онуудад импортын өсөлт өндөр байж урт хугацааны хандлагаас давсан. 2023 онд эдийн засаг идэвхжил нэмэгдсэнээр импорт 9.2 тэрбум | 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ам.долларт хүрч урт хугацааны хандлагаас дээгүүр хадгалагдаж байна. Хавсралт: 1 файл | | | |
| 1.3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлнэ. | | | | | | | | |
| 10 | Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсан. | - | "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай" хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024.04.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд 16 дугаар тэмдэглэлд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу 2024.04.30-ны өдөр "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай" хуулийн төслийг 2024.04.30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Монгол Улсын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй холбоотойгоор Төсвийн байнгын хороо, Улсын Их хурлын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт хэлэлцүүлэхэд төсвийн тооцоолол, танилцууллагыг тухай бүр бэлтгэж, 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр батлуулсан. Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр өөрчлөлт орсонтой холбоотойгоор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулан Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж 2024 оны 11 сарын 8-ны өдөр батлуулсан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |
| 11 | ЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Боловсруулсан төлөвлөгөө, тайлан. | - | Жилийн эцсийн ТЖАХ-ийн гүйцэтгэлийн тайлан. | “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан. Мөн өөрт цохогдсон албан бичгийг цохих хугацаанд судлан, хариуг хүргүүлэн ажилласан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субъект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх | Хариуцсан ажил үүрэгтэй холбоотой хурал зөвлөгөөн, сургалт семинарт хамрагдах | - | Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх | Ажлын цагийг үр дүнтэй ашиглаж ажилласан бөгөөд мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд ОУВС-ийн "Macroeconomic analysis/Financial Programming and Policies" сургалтад хамрагдсан | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 2 | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх | Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх | - | Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт хамрагдсан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Төлбөрийн тэнцэл хариуцсан мэргэжилтэн, Жамбалбавуу Өлзийсайхан /......Өлзийсайхан....../ Огноо: 2024.12.18 .........................

212